4. Сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээллийн сан бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ХНХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор нь дотоод аудиторын тайланд тус байгууллагын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар дурдсан зүйл байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,466,567.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,665.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2021 оны жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 135,276.1 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад урьдчилж төлсөн зардал, хангамжийн материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн данснууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 47,241.5 | 5,087.5 | (42,154.0) |
| Урьдчилж төлсөн төлбөр | 328,299.6 | | (328,299.6) |
| Бараа материал | 60,069.3 | 77,869.7 | 17,800.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,972,492.9 | 2,189,869.9 | 217,377.0 |
| **Нийт хөрөнгө** | **2,408,103.3** | **2,272,827.1** | **135,276.1** |
| Өр төлбөр | 18,101.4 | 274.0 | 17,827.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,390,001.9 | 2,272,553.1 | 117,448.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,408,103.3** | **2,272,827.1** | **135,276.1** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 47,241.5 мянган төгрөг байсныг тайлант хугацаанд цуглуулсан.

- Урьдчилж гарсан тооцоо дансанд гарсан өөрчлөлт нь ХНХЯ-аас салбарын сургалт удирдлагын нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлэлт 220,000.0 мянган төгрөг, ГОУХАН-ийн санхүүжилтээр цахим сургалтын тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын урьдчилгаа төлбөр 108,199.6 мянган төгрөг нийт 328,299.6 мянган төгрөгийн ажлыг тайлант онд ашиглалтанд хүлээн авснаар буурсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 77,869.7 мянган төгрөг болж 17,800.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 126,223.5 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан 37,377.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 30,408.2 мянга, тайлант онд зарцуулсан 115,394.6 мянган төгрөгөөр хасагдсан.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,189,869.5 мянган төгрөг болж өөрчлөгдсөн нь худалдан авсан 638.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 155,191.0 мянга, дахин үнэлсэн 101,050.0 мянга, урьд оны тооцооноос 356,851.2 мянгаар нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны шийдвэрийн дагуу 448,421.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 199,227.5 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутаг дахь мэргэжил сургалтын төв болон политехник коллеж, ХНХЯ-нд шилжүүлсэн.
- Санхүүгийн Тооцоолох Групп ХХК-с санхүүгийн программ хангамж 638.0 мянган төгрөгөөр худалдан авснаас биет бус хөрөнгө өссөн.
- Өр төлбөр данс өмнөх оны НДШ-н өр 6,160.0 мянга, ХХОАТ 3,510.2 мянга, цалин хөлсний өр 3,181.3 мянга, байгууллагад төлөх өр 5,250.0 мянган төгрөгийн өглөгөөр буурсан.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,272,553.1 мянган төгрөг болж 135,276.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдлаас шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 938,594.8 мянган төгрөгөөр тооцон урсгал зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 29,263.5 мянган төгрөгөөр бууруулж 909,331.3 мянган төгрөгөөр баталсан.

Үүнд: Цалин хөлс, нийгмийн даатгалын зардал 4,599.8 мянга, ашиглалтын зардал 12,989.2 мянга, томилолтын зардал 5,013.3 мянга, хангамж бараа материал 2,535.2 мянга, бусад зардалтай холбоотой 4,126.0 мянган төгрөг байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр ийн2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 909,331.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 703,481.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 205,850.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 650,297.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 249,802.2 мянган төгрөг нийт 900,100.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 855,406.1 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 56,958.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 205,850.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 249,802.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 17.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 900,100.0 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь улсын төсвийн орлого буурсантай холбоотой.

Урсгал зардлын гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад бүлгийн дүнгээр хэмнэлттэй харагдаж байна. Тухайлбал:

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь цалин хөлсний зардал 54,302.9 мянга, цэвэр бохир усны зардал 3,216.4 мянга, шуудан холбооны зардал 1,735.1 мянга, аудит баталгаажуулалт 1,000.0 мянга, мэдээллийн технологийн зардал 2,765.2 мянга, дотоод албан томилолтын зардал 416.2 мянган төгрөгөөр тус бүр дутуу гүйцэтгэлтэй.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөг/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| **1** | **71804** | **Тусгай мэргэжлийн боловсрол** | **909,331.3** | **900,100.0** | **9,231.3** | **99.0** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал | 864,637.4 | 855,406.1 | 9,231.3 | 98.9 |
| 1.2 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 44,693.9 | 44,693.9 | - | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаадын төсөл хөтөлбөрөөс 303,981.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 211,797.3 мянга, Озоны үндэсний төв, Хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг дээшлүүлэх сан, Жолооны сургалтын багш нарыг чадавхижуулах сургалтын орлого 65,568.4 мянга, нийт 581,347.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Цалин хөлсний зардал 22,460.7 мянга, нийгмийн даатгалын зардал 4,642.5 мянга, бичиг хэргийн зардалд 2,556.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 525,739.8 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 25,750.0 мянга, нийт 581,149.0 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 198.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн Дугаар А/473,А/221 тоот хамтарсан тушаалаар Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх чиг үүргийг шилжүүлэх, хүлээлгэн өгөх ажлын хэсгийг байгуулан мэргэжлийн сургалт явуулах чиглэлийг шилжүүлэхтэй холбоотой орон тоо, бүтцийг өөрчлөхөөр хүлээгдэж байна.

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэнд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.0 хувийн биелэлттэй, 1.0 хувь буюу 9,231.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг тооцон мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналын гүйлгээг тулган Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь,1 мэдээ хугацаа болоогүй, 14 мэдээлэл хугацаа хоцроож байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “ Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тайлант онд 110,800.0 мянган төгрөгийн 2 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж бараа, ажил үйлчилгээ худалдан авсан. Үүнээс 118 нэр төрлийн 505.0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг бүртгээгүй, техникийн тодорхойлолтонд заагдаагүй 4 нэр төрлийн 312.0 мянган төгрөгийн бараа материалыг илүү орлого авч бүртгэсэн нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-т “Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэж заасантай нийцэхгүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа гэрээний биелэлтийг дүгнэж, бараа материалыг орлого авч акт үйлдэж, чанар байдал тоо хэмжээнд хяналт тавьж хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 299,819.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 4 зөвлөмж тайлант хүргүүлснээс худалдан авах үйл ажиллагаа, өр төлбөр, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө, дотоод хяналт, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой зөвлөмж, албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн бол тайлант онд цахим баримттай холбоотой албан шаардлагыг 99,7 хувиар, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой албан шаардлагыг 80 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт*

***/мянган төгрөг/***

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | - | 1 | - | - | - | 98.3 |
| Зөвлөмж | 4 | 30,450.0 | 1 | 26,585.4 | 1 | 3,864.6 | 93.7 |
| **Нийт дүн** | **8** | **30,450.0** | **2** | **26,585.4** | **1** | **3,864.6** | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн шалгалтын барилга байгууламжийн газрын Г22010162571 дугаар бүхий газар эзэмших гэрчилгээ нь өмнөх эзэмшигчтэй холбоотой нийгмийн даатгалын өрийн битүүмжлэлд Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1325 дугаар шийдвэр, 1296 тоот гүйцэтгэх хуудас, 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 18360331/2 дугаартай эд хөрөнгө битүүмжлэх тухай 18360331/2 дугаар тогтоолоор битүүмжлэгдсэн байгааг дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 988,548.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 976,464.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,575.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны хэрэгжилтэнд албан шаардлага, 9,509.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1,470.0 мянган төгрөгийн элэгдлийг бусад хөрөнгийн элэгдлийн дансанд тодруулсан;
2. Цалин хөлсний тооцооны өглөгт 176.1 мянган төгрөг илүү тайлагнасан;
3. Тайлант онд 1,352.6 мянган төгрөгийн худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим системд бүртгүүлсэн;
4. 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн 2021 оны жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн уялдаа тооцооллыг шалгахад 973,465.8 мянган төгрөгийн зөрүүг тус бүр залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Тайлант онд 25,750.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо 2,575.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтууд, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *4.3.1 Бараа материалын данстай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Аж ахуйн зориулалттай 27 нэр төрлийн 1,767.2 мянган төгрөгийн бараа материалыг бичиг хэргийн дансанд орлогод бүртгэж зарцуулсан.

*Өгсөн зөвлөмж:*

УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” гэж заасны дагуу бараа материалын ангиллыг тууштай баримтлан бүртгэхийг зөвлөж байна.

#### *4.3.2 Зардлын ангилалтай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Тайлант онд (багаж хэрэгсэл, мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс, гэх мэт) нийт 1,56.3 мянган төгрөгийг батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь толилуулга ба тодруулга болон хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангаагүй ба

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврын дагуу зориулалтаар нь зарцуулах.

#### *4.3.3 Балансын данстай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Тайлант онд авлага дансны үлдэгдэл 5,087.5 мянган төгрөг, өглөг дансны 274.0 мянган төгрөг үлдэгдэлтэй байгаа нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д зааснаар “Төсвийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг баримтлан авлага, өглөгөө барагдуулан, үлдэгдэлгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар** | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв | АХГ-2022/229/НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1,470.0 мянган төгрөгийн элэгдлийг бусад хөрөнгийн элэгдлийн дансанд тодруулсан | | 1 | 1,470.0 | 1 | 1,470.0 | | | | | | | | |
| 2 | | | Цалин хөлсний тооцооны өглөгт 176.1 мянган төгрөг илүү тайлагнасан | | 1 | 176.1 | 1 | 176.1 | | | | | | | | |
| 3 | | | Тайлант онд 1,352.6 мянган төгрөгийн худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим системд бүртгүүлэн | | 1 | 1,352.6 | 1 | 1,352.6 | | | | | | | | |
| 4 | | | 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн 2021 оны жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн уялдаа тооцооллыг шалгахад 973,465.8 мянган төгрөгийн зөрүү үүссэн. | | 1 | 973,465.8 | 1 | 973,465.8 | | | | | | | | |
| 5 | | | Тайлант онд 25,750.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо 2,575.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй. | Төлбөрийн акт тогтоох. | 1 | 2,575.0 | | | 1 | 2,575.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | | Аж ахуйн зориулалттай 27 нэр төрлийн 1,767.2 мянган төгрөгийн бараа материалыг бичиг хэргийн дансанд орлогод бүртгэж зарцуулсан. | УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” гэж заасны дагуу бараа материалын ангиллыг тууштай баримтлан бүртгэхийг зөвлөж байна. | 1 | 1,767.2 | | | | | | | | | 1 | 1,767.2 |
| | | | Тайлант онд (багаж хэрэгсэл, мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс, гэх мэт) нийт 1,563.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагад мөрдөгдөх зардлын ангиллын дагуу бүртгээгүй. | Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврын дагуу зориулалтаар нь зарцуулах. | 1 | 1,563.3 | | | | | | | | | 1 | 1,563.3 |
| | | | Тайлант онд авлага дансны үлдэгдэл 5,087.5 мянган төгрөг, өглөг дансны 274.0 мянган төгрөг үлдэгдэлтэй | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг баримтлан авлага, өглөгөө барагдуулан, үлдэгдэлгүй ажиллах. | 1 | 5,361.5 | | | | | | | | | 1 | 5,361.5 |
| **Санхүүгийн тайлангийн аудитын дүн** | | | | | **8** | **987,731.5** | **4** | **976,464.5** | **1** | **2,575.0** | | | | | **3** | **8,692.0** |
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв | АХГ-2022/229/НА-СТА-ТШЗ | Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь,1 мэдээ хугацаа болоогүй, 14 | Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох | 1 | | | | | | 1 | | 1 | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. | албан шаардлага хүргүүлэх. | | | | | | | | | | | | |
| 8 | | | 118 нэр төрлийн 505.0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг бүртгээгүй, техникийн тодорхойлолтонд заагдаагүй 4 нэр төрлийн 312.0 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч бүртгээгүй нь | Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрдээ гэрээний биелэлтийг дүгнэж, бараа материалыг орлого авч акт үйлдэхдээ чанар байдал тоо хэмжээнд хяналт тавьж хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх. | 1 | 817.0 | | | | | | | | | 1 | 817.0 |
| **Нийцлийн аудитын Дүн** | | | | | **2** | **817.0** | | | | | **1** | | **1** | | **1** | **817.0** |
| **Нийт дүн** | | | | | **10** | **988,548.5** | **4** | **976,464.5** | **1** | **2,575.0** | **1** | | **1** | | **4** | **8,684.0** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 37/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/229/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелээгүй тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 152 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээ хугацаа болоогүй, 14 мэдээлэл хугацаа хоцроон байршуулж алдаа зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн Ерөнхий нягтлан бодогч У.Энххүүд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Ч.ЭРДЭНЭЖАВ

9006109
20191120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-62.Docx

001080191

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 03/А0150058 Улаанбаатар хот

АХГ-2022/229/НА-СТА-ТӨ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 25,750,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо 2,575,000 төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв акт тогтоосон дүн 2,575,000 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв дарга Ц.Батдорж, Ерөнхий нягтлан бодогч У.Энххүү нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Ч.ОЮУН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-14.Docx

001090055

ТЭМДЭГЛЭЛ